



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 06 сарын 15 өдөр

Дугаар A/215

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 5.4.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Нислэгийн ярианы бичлэгийн системийн шинэчлэл 4 иж бүрдэл /Улаанбаатар, Хэнтий/” нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:	Г.Баттөгс	Холбоо, навигаци, ажиглалтын албаны Техник технологи инженерингийн хэсгийн дарга
Нарийн бичгийн дарга:	Ч.Чимэдноров	Худалдан авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн
Гишүүд:	Д.Отгонхүү	Холбоо, навигаци, ажиглалтын албаны Техник төлөвлөлт, инженерингийн хэсгийн лабораторийн технологич инженер
Г.Ганзориг		Монголын Аэронавигаци, инженер техникийн ажилтнуудын холбооны гишүүн
Б.Мэндсайхан		“ХУД ЯАРМАГ” Төрийн бус байгууллагын зөвлөх

2. Нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо /Г.Баттөгс/-нд үүрэг болгосугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, тендер нээхэд үнэлгээний хорооны гишүүддээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Хуулийн хэлтэст хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Ч.Чимэдноров/-д даалгасугай.

ДАРГА

П.МӨНХЖАРГАЛ



1721 01 1260